

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын сар тутмын сонин 2017 оны 11 сарын дугаар

Тэргүүн Мэдээ

“Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулийн барилга барих төсөл”-ийн гэрээнд (G/A) гарын үсэг зурав



Гарын үсэг зурах ёслол

11 сарын 30-нд буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжих “Улаанбаатар хотын ерөнхий боловсролын барилга барих төсөл”-ийн 2 тэрбум 379 сая иений гэрээнд гарын үсэг зурав. Энэхүү төслийн хүрээнд Улаанбаатар хотод ерөнхий боловсролын 4 сургууль барих бөгөөд байгаль орчны арга хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ашиглах болон гамшгаас хамгаалах зориулалтаар ашиглах боломж зэрэг цогц шийдлийг зураг төсөлд нь тусгахаар төлөвлөж байна. Энэхүү төсөл хэрэгжсэнээр сургуулийн барилга байгууламжийн хүрэлцээ сайжрахын хамт монголын сургуулийн барилгын загвар бий болж, цаашид сургуулийн барилгыг чанартай барих ажлыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулна гэж найдаж байна. Мөн одоо хэрэгжиж буй техникийн хамтын ажиллагааны “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-тэй хамтран ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон бусад хэн ч ашиглаж болох сургууль барихад материаллаг ба материаллаг бус талын дэмжлэг үзүүлэн монголын сургуулийн орчныг цогцоор нь сайжруулахад хувь нэмэр оруулахыг зорьж байна.

Улс төрийн, эдийн засгийн чиг хандлага

2018 оны улсын төсөв батлагдав

УИХ-ын намрын чуулганы 11 сарын 14-ны өдрийн хуралдаанаар 2018 оны Улсын төсвийн төслийг хэлэлцэн батлав. 2018 оны улсын төсөвт ДНБ-ний өсөлтийг 4.2 хувьд хүргэж, төсвийн алдагдлыг ДНБ-ний 8 хувь (2.4 их наяд төгрөг) хүртэл бууруулахаар тооцож, хүүхэд өсгөж буй эх болон өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж, сургуулийг 2 ээлжээр хичээллэдэг болгоход шаардлагатай сургууль барих зардлыг тусгасан байна. ОУВС-ын хөтөлбөр хэрэгжин, нүүрс зэрэг түүхий эдийн үнэ сэргэж, ДНБ өсч, гадаад валютын нөөц нэмэгдэх зэргээр эдийн засаг сэргэх найдвар төрж байгаа боловч багш, эмнэлгийн ажилтнууд цалин нэмэх шаардлагаа үргэлжлүүлэн тавих зэргээр төсвийн зарцуулалтыг өсгөх шахалт хүчтэй болох магадлалтай байна. Санхүүг сэргээн босгох арга хэмжээг үргэлжлүүлэн хөрөнгө оруулалтын орчныг боловсронгуй болгож эдийн засгийг төрөлжүүлэх зэрэг эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн арга хэмжээг бодитойгоор авч хэрэгжүүлж чадах эсэхийн хувьд одоогийн Засгийн газар Монголын эдийн засгийн ирээдүйн хөгжлийн түлхүүрийг атгаж байна гэж хэлж болно.

Ерөнхий сайд У.Хүрэлсүх МАН-ын дарга боллоо

11 сарын 20-21-нд МАН-ын их хурал хуралдан, ерөнхий сайд У.Хүрэлсүх бусад нэр дэвшигчдийг ялж МАН-ын даргаар сонгогдоо. У.Хүрэлсүхийг Ерөнхий сайдаар томилох үед өмнөх Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг дэмжигч УИХ дахь МАН-ын бүлгийн олон гишүүн санал хураалтад оролцоогүй гэх мэтээр намын дотоод фракцуудын зөрчил ил гарч ирсэн бөгөөд Ерөнхий сайд намын даргаар сонгогдсоноор Засгийн газар тогтвортой ажиллаж чадах уу үгүй юү гэдэг асуудал анхаарал татаж байна.

Төслийн хэрэгжилт

“Япон-монгол сургалтын эмнэлэг барьж байгуулах төсөл”-ийн барилгад бүтээцийн үндсэн ажил дууссаны ёслолын ажиллагаа болов



Ёслолын ажиллагаанд оролцож буй зочид төслийг хэрэгжүүлэгчид

11 сарын 3-нд буцалтгүй тусламжийн хамтын ажиллагаагаар хэрэгжиж буй “Япон-монгол сургалтын эмнэлэг барьж байгуулах төсөл”-ийн хүрээнд Баянзүрх дүүрэгт баригдаж буй уг эмнэлгийн барилгын үндсэн бүтээцийн ажил дууссаны ёслолын ажиллагаа болов. Энэ өдөр Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга З.Энхболд, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл зэрэг албаны хүмүүс ёслолын ажиллагаанд оролцов. Энэхүү төслөөр Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяаны эмнэлэг болох Монголын анхны сургалтын эмнэлэг баригдаж байгаа юм. Тэрчлэн төслийн хүрээнд эмнэлгийн барилгыг барихын хамт шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх бөгөөд Монгол улсын эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулна гэж найдаж байгаа юм. Барилгын ажлыг 2018 оны 7 сард дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

“Хүлэмжийн хийн тооллого хийх чадавхийг бэхжүүлэх замаар үндэсний хүлэмжийн хийн тооллогын мөчлөгийг тасралтгүй сайжруулах төсөл” хэрэгжиж эхлэв



Төслийн үйл ажиллагаа эхэлж буйтай холбогдуулан БОАЖ-ын сайдтай санал солилцож байгаа нь

11 сарын 22-ны өдөр БОАЖЯ, Уур амьсгалын сан хариуцан хэрэгжүүлэх ТХА-ны “Хүлэмжийн хийн тооллого хийх чадавхийг бэхжүүлэх замаар үндэсний хүлэмжийн хийн тооллогын мөчлөгийг тасралтгүй сайжруулах төсөл”-ийн үйл ажиллагааг эхлүүлж хамтрагч талууд анхны хурлыг зохион байгуулав. Энэхүү төсөл нь уур амьсгалын өөрчлөлтийн талаар авах арга хэмжээний ач холбогдол өндөрсөж буй өнөөгийн нөхцөл байдалд хүлэмжийн хийн тооллогын системийг боловсруулах чадавхийг дээшлүүлэх зорилгоор хэрэгжих юм. Хурлаар төслөөс гарах үр дүн, үйл ажиллагааны агуулга, цаг хугацааны талаар санал солилцсон бөгөөд цаашид ажлын хэсгийн хүрээнд 2018 оны 1 сард төслийн Хамтарсан зохицуулах хорооны анхны хурлыг зохион байгуулахаар талууд санал нэгдэв.

“Монгол улсын Шударга өрсөлдөөний орчныг сайжруулах төсөл”-ийн хүрээнд өрсөлдөөний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар олон нийтийн санал авах 2-р хэлэлцүүлэг болов



Олон нийтээс санал авах хэлэлцүүлэг

Техникийн хамтын ажиллагаа “Монгол улсын Шударга өрсөлдөөний орчныг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Японы Шударга худалдааны хорооны хамтын ажиллагаагаар дамжуулан Монгол улсын өрсөлдөөний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажилд дэмжлэг үзүүлж байна. 11 сарын 9-нд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ) болон ЖАЙКА хамтран холбогдох яам, агентлагийн 80 гаруй хүн оролцсон олон нийтээс санал авах 2 дахь хэлэлцүүлгийг зохион байгуулж, хуулийн нэмэлт өөрчлөлтийн агуулгыг авч хэлэлцэв. Семинарт оролцсон ЖАЙКА-ийн мэргэжилтэн Хара нь (Японы Шударга худалдааны хороо) өрсөлдөөний хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл нь шударга өрсөлдөөний байгууллагын бие даасан байдлыг хангаж байгаа гэсэн утгаараа санал нэг байгаагаа илэрхийлэв. Тус семинар дээр Шадар сайд Ө.Энхтүвшингийн зүгээс уг төсөл нь Монгол улсын Шударга өрсөлдөөний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажилд чухал ач холбогдол өгч байна гэж төслийн үйл ажиллагааг өндрөөр үнэллээ.

“Амьдрахад таатай, тогтвортой хотуудын хот төлөвлөлт” Япон-Монголын хамтарсан семинар боллоо



Семинарын байдал

11 сарын 20-нд Япон, Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойн арга хэмжээний хүрээнд БХБЯ-ны санаачилгаар “Амьдрахад таатай, тогтвортой хотуудын хот төлөвлөлт” Япон-Монголын хамтарсан семинар зохион байгуулагдав. Энэхүү арга хэмжээнд холбогдох яам агентлаг, орон нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнууд оролцож, ЖАЙКА болон Япон Монголын бусад холбогдох байгууллагуудаас авч хэрэгжүүлж ирсэн арга хэмжээг танилцуулахын хамт Японы хот ба хүрээлэн буй орчны хөгжлийн судалгааны хүрээлэнгийн ТУЗ-ын дарга Тонума Коичи (Японы хот төлөвлөгчдийн холбооны тэргүүн асан) лекц уншиж, Японы хот төлөвлөгчдийн холбооны видео мэндчилгээг дамжуулж, Монгол Улсын амьдрахад таатай, тогтвортой хот ямар байх ёстой талаар авч хэлэлцэв. Оролцогчдын зүгээс агаарын бохирдол, нийтийн тээврийн асуудал зэрэг Улаанбаатар хотын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн хот төлөвлөлтийн хандлага, арга барилыг санал болгох, нийслэл хотын хэт төвлөрлийг сааруулах үүднээс орон нутгийг хөгжүүлэхийн ач холбогдолыг тэмдэглэх зэргээр баялаг агуулгатай семинар болов.

ЖДҮ-ийн санхүүжилтийн тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлж буй мэргэжилтэн алтан гадас одонгоор шагнуулав



Шагнал гардуулах ёслол дээр дурсгалын зураг авахуулж буй ноён Сунагава

11 сарын 10-нд Монгол улсын ЖДҮ-ийг дэмжин хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн ноён Макото Сунагаваг (Koei Research & Consulting Co., Ltd.) гадаадын иргэдэд олгодог хамгийн дээд зэрэглэлийн одон болох Алтан гадас одонгоор шагнав. Ноён Сунагава нь иений хөнгөлөлттэй зээлээр хэрэгжсэн “ЖДҮ-ийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 шаттай төсөл I, II”-ийн зөвлөхийн хувьд ЖДҮ болон санхүүгийн зууч байгууллагын чадавхийг дээшлүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллаж ирсэн бөгөөд одоо техникийн хамтын ажиллагааны мэргэжилтний хувьд ЖДҮ-ийн санхүүжилтийн тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Ноён Сунагавгийн олон жилийн хүчин зүтгэлийг өндрөөр үнэлэн энэхүү одонгоор шагнасан бөгөөд шагнал гардуулах ёслол дээр ерөнхийлөгч Х.Баттулга өөрийн биеээр хоён Сунагавад одонг зүүж өгсөн байна.

Сайн дурын үйл ажиллагаа

Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга (Нийгмийн халамжийн салбарт хамтран ажиллах сайн дурын гишүүд)



Оюутнуудад заавар өгч буй Оно сайн дурын гишүүн

Монгол улсад нийгмийн халамжийн салбарт ажиллах сайн дурын гишүүдийг үргэлжлүүлэн илгээсээр байна. Тэдний нэг нь сайн дурын гишүүн Оно Юки (2016 оны 2 сар/нийгмийн ажилтан (SWr)) бөгөөд Дорнод аймгийн дээд сургуулийн багш оюутнуудад японы нийгмийн ажилтнуудын гүйцэтгэдэг үүрэг, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар танилцуулан орон нутгийн нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах чиглэлээр ажиллаж байна. Анх япон, монголын нийгэм олон талын ялгаатай тул японы мэдлэг нэмэр болох болов уу гэж санаа зовж байсан боловч хичээлд сууж, багш, оюутнуудтай харилцах явцад японы нийгмийн ажилтны гүйцэтгэдэг үүргийг танилцуулах явдал бол өөрийнх нь хийх ёстой ажил юм байна гэдгийг ойлгосон гэнэ. Монголын нийгмийн ажилтнууд ерөнхийдээ багаар ажиллах чадвар (Жишээлбэл эрүүл мэндийн нийгмийн ажилтан нь сувилагч, нөхөн сэргээх эмч нартай хамтран ажиллах зэрэг) тааруу байдаг боловч багш, оюутнууд өөрсдөө асуудлыг шийдвэрлэх арга замыг японтой харьцуулан эрэлхийлж, нийгмийн ажилтан нь харьцангуй зүй зохистой байдлаар нийгэмтэй холбогдон ажил үүргээ гүйцэтгэдэг болох нь өнөөдрийн зорилго гэж үзэж байгаа юм байна. Японы нийгмийн ажилтаны гүйцэтгэдэг үүргийг зөв танилцуулан, санаа авахуйц, хэрэг болох юмыг нь авч хэрэглэх замаар монголын нийгмийн ажилтны чанарыг сайжруулахад бага ч гэсэн нэмэр болохын тулд хичээн ажиллаж байна.

Сайн дурын бусад үйл ажиллагааны тухай мэдээ

- Дэлхийн халуун өнцөг өгүүлэл: Масуда Такуми сайн дурын ажилтан (2016 оны 2 сар/Бизнесийн удирдлага/ МҮХАҮТ) “Их талыг нэвт туулсан нь: Монголд болсон Олон улсын талын марафоныг зохион байгуулах ажилд оролцсон тухай.” → Линк [Энд дар](#)



ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбоо

Төгсөгчдийн холбооны 2017 оны “Follow Up” семинар зохион байгуулах сэдвүүдийг тогтлоо



2016 онд зохион байгуулсан семинарын явц

ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбооноос ЖАЙКА-ийн Япон дахь сургалтын туршлагыг Монголд улсад түгээн дэлгэрүүлэх үүднээс сургалтанд оролцогчид Японд болсон сургалтын үр дүнг танилцуулан сургалтанд оролцож чадаагүй бусад хүмүүстээ хүргэх зорилготой “Follow up” семинар зохион байгуулдаг. Семинар зохион байгуулах квот хязгаарлагдмал байдаг боловч жил бүр олон тооны семинарын санал ирдэг тул Сургалт төгсөгчдийн холбооны Удирдах зөвлөл сонгон шалгаруулалт хийдэг. 2017 онд 19 семинарын санал хүлээж авсан бөгөөд Удирдах зөвлөл салбар тус бүрээр сонголт хийсний үр дүнд “Өндөр настны эрүүл мэндийг сайжруулахад өрхийн сувилагчийн оролцоо” (Эрүүл мэнд), “Хичээлийн судалгаа” (Боловсрол), “Японы өр дуудах төвийн туршлага” (Татвар), “Байгаль орчны боловсрол” (Байгаль орчин), “Хүнсний аюулгүй байдал” (ХАА) гэсэн сэдвүүдийг сонгосон байна. 12 сарын 1-нээс эхлэн эдгээр сэдвүүдээр семинар зохион байгуулагдахаар боллоо.



Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)

Монгол дахь төлөөлөгчийн газар

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс
(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 Имэйл: mg_oso_rep@jica.go.jp